



1.Нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил, онцлогийн талаар

Газар нутаг: Өлзийт тосгон нь Улаанбаатар хотоос 280 км, Өндөрхаан хотоос 50 км, мянганы замаас 12 км зайд оршдог.

Газар нутаг 146,7 мянган га

Тариалангийн талбай -22000га

Хадлангийн талбай -3600га



4.2 Экологийн онцлог

Далайн төвшнөөс дээш 1600 метр өргөгдсөн Төв Азийн хойд хагаст Монголын өргөн уудам нутгийн зүүн хагаст Хэнтийн уулархаг нутгийн шувтрах үзүүр, Хэрлэн голын хойд биеэр нутагтай Мөрөн сумын хойд Номгоны уулсын дунд оршдог.

Тус тосгоны нутагт 160-200 мм хур тунадас ордог. Салхины чиг гол төлөв баруунаас дундаж хурд 9-15м/с, Агаарын дундаж температур -1 +2 градус, хамгийн халуун нь 7-р сард +38-42 градус, хамгийн хүйтэн нь 12-1-р сард -48.2 градус хүрдэг.

4.3.Газар зүйн байршил:

Тосгоны төв намхан уулс дунд Мөрөн голын эрэг дагуу далайн төвшнөөс дээш 1200 орчим метр өндөрт оршдог. Урд болон баруун урд талаараа Мөрөн сумтай засмал замын дагуу, баруун талаараа Манхан толгойн утасны цэг, Бумбагарын улаан өндөр 1533,2м, Хавтгай 1474,4 м, Хар өндөр 1469,7 м, Өндөр толгой, Зуухын гацаа, Зуухын цагаан толгой, Дунд Өлгий, Хажуу булаг зэрэг газруудаар Жаргалтхаан сумтай, хойд талаараа Ерөөлт, Баянцогт, Баруун-Зүүн Чандган, Худгийн толгой, Хойд Зотлог 1460,7м, Талын булгийн Цагаан толгой зэрэг нутгаар Өмнөдэлгэр сумтай, Зүүн талаараа Саригийн гол, Дунд уул зэрэг газруудаар Тахилгат тосгонтой хил залган оршдог тал хээрийн бүс нутаг юм.

Тал хөндий-Шорвогийн тал, Чандган тал

Гол мөрөн-Мөрөн гол урт нь 40км, гүн нь 0,2-0,5 м, усны урсгалын хурд 0,5м/с

2. Хүн амын тоо, яс үндэс, соёл, уламжлал, ёс заншлын талаар

- Хүн ам 1047
- Нийт өрх 325
- Нийт өрхийн 10% казак, 23% урианхай, бусад үлдэх хувийг халх болон бага ястангууд эзэлж байна.

Өлзийт тосгон нь олон үндэстэн ястны өлгий нутаг юм. Нийт хүн амын 10 хувийг эзэлдэг Казак үндэстний соёл, уламжлал, ёс заншлыг хадгалах үүднээс жил бүр Наурызын баярыг өргөн дэлгэр тэмдэглэж байна.




3. Нутгийн брэнд бүтээгдэхүүн

Казак эмэтэйчүүд нь малынхаа сааль сүүгээр ааруул, ээзгий, давсалсан шар тосыг их хэмжээгээр хийж хүнсэндээ хэрэглэдэг. Энэ нь элэг, дотрын өвчлөлийг анагаах эрүүл мэндэд ач тустай бүтээгдэхүүн юм.



4. Малын тоо, ангилал, сүүлийн 4 жилээр

Мал	2012он	2013он	2014он	2015он	2016он
Тэмээ	68	60	65	72	69
Адуу	2982	4343	4594	4470	4599
Үхэр	2836	3043	3640	3943	3683
Хонь	25867	29805	28645	29486	28288
Ямаа	19866	21712	22417	23471	23936
Бүгд	51619	58963	59361	61442	60575



5.Амьтан, ургамлын аймаг, төрөл зүйл, ангиллын талаар

Хөрс: Хөрсний тогтоц шинж чанар Хүрэн, хүрэвтэр, шаваранцар хөрстэй. Ялзмагт ус дунд зэрэг 3,32%-ийн ялзмагтай. Ерөнхий азот нь 3,31%, фосфорын исэлийн агуулга : Хөрс хуурайвтар

Ургамлын аймгийн төрөл нь: Тал хээрийн өвслөг ургамал зонхилдог.

Ой модны төрөл, говь цөлийн ургамал талбай байхгүй.

Дэрвээнэ



Хатсан иш нь намар салхинд хийссэн харгана сөөгөнд орооцолддог тул хазаар өвс хэмээн нэрлэгдсэн 10-30см намхан, дээшээгээ дэрвэгэр бутыг үүсгэдэг олон наст үет ургамал юм. Навч нь ихэнхдээ хавтгай байх ба гантай үед хуйлмал болсон байдаг. Голын хайрга байц, чулуурхаг хажуу, хээр талд, хөнгөн ба дунд зэргийн шавранцар хар хүрэн, хүрэн хөрсөнд ургана.

Далан түрүү

Орон нутгийн нэр нь чонын хөлбөдөс, түвэг залаа.

Хэнтий, Дорнод зэрэг нутгаар тархсан. Ойт хээрийн бүслүүрт чулуурхаг ба хадархаг хээржүү хажуу, нугархаг хээр, ойн нуга ба зах, атаржсан газар ургана. Махлаг бүдүүн голлосон үндэстэй. Нягт шигүү бутгаар ургадаг, заримдаг сөөгөнцөр. Иш нүцгэн, бүдүүн эгц, олон 20-30 см өндөр, уг нь модорхог. Навчис юлдэрхүү, цувраа 1-2 см урт, 3-8 мм өргөн. Цэцэг цагаан, ягаан цагаан, ягаан. Цэцэглэх үрлэх хугацаа: 6-7, 7-8 сар. Арьсны өвчин, бэтэг, шамбарам, яр шарх, зүрх цэр ихтэй ханиад, түрүү булчирхайн сүрьеэ зэрэгт тустай.

ГАНГА



Газар доор уг нь ихэд модожсон, мөлхөө иштэй, заримдаг сөөгөнцөр ургамал. Навчис жижиг, тонгоруу өндгөрхүү хэлбэртэй, бүтэн, үсэрхэг. Цэцэг жижигхэн, 2 уруултай, ишний үзүүрийн навчны өвөрт байрладаг, ягаан өнгөтэй. Самранцар жимстэй. Ягаан цэцэгтэй. Цэцэглэх хугацаа 6, 7-р сар. Уулын хээрийн бүслүүр, говь цөл, хээрийн бүсэд байц цохио, асга, хайргархаг ба чулуурхаг хээржүү хажуу, эрэг дагасан хайр, нүүдэггүй

элсэнд ургана. Үсийг гангаар угаавал уртасдаг. Шанпунь хийдэг ашигт ургамал мөн эмчилгээний зориулалттай. Анхилуун содон үнэртэй. Цэцэглэснээс хойш 8-р сарын сүүлч хүртэл фотосапари аялалд ашиглах боломжтой. Мөн үнэрийг нь ашиглан бэлэг дурсгалын зүйлд шингээх боломжтой.

Өдлөг хялгана



Латинаар: Stipa Pennata нь элсэрхэг хээр, их элсний зах, уулын чулуулаг хайргатай бэлд ургадаг олон наст өвслөг ургамал юм. Баруун хангай, Монгол Дагуурт тохиолдоно. Нөөц маш бага, үрээр үржиж, нахианаасаа жил бүр эрчимтэй сэргэж ургана.

МӨЛХӨӨ ГИЧГЭНЭ



Газар дээр үндэслэгддэг, зэллэсэн, улаан цурав иштэй, намхан ургадаг, олон наст өвслөг ургамал. Навч өдөлсөн нийлмэл, ар, өвөр талдаа мөнгөлөн цайвар, торгомсог үсжилттэй, хурц шүдэрхэг ирмэгтэй. Цэцэг шар, ганц нэгээрээ цэцэгт ишний оройд байрлана. Самранцар жимстэй. Цэцэглэх хугацаа 6, 7-р сард. Монгол орны байгалийн бүх бүс бүслүүрт эргийн чийглэг нуга, хужирлаг нуга, гол нуурын эрэг, намгархаг нуга, замын дагууд ургана. Газрын дээрх биеийг цус алдалт, гүйлгэх үед хэрэглэнэ. Анхилуун үнэртэй.

Агь



Монгол оронд гол төлөв ойт хээр болон хээр талын бүсэд элбэг ургадаг. 10-40 см өндөртэй. Саравгар ишт, олон нас заримдаг сөөгөн ургамал. Шаравтар өнгөтэй жижиг бөмбөлөг хэлбэрт сагс баг цэцэгтэй. Түүний иш навч гадуураа саарал юм уу? бор ногоон өнгөтэй торгомсог үсээр хучигдсан байна. Агь хавар эрт цухуйдаг бэлчээрийн ач холбогдолтой ургамал.

Хөх яргуй



Үндэслэг иштэй, хавар эрт навчлахын хамт цэцэглэгч, олон наст, 10-15 см өндөр ургадаг өвслөг ургамал. Хөх ягаан өнгөтэй, том хонхон хэлбэрийн цэцэгтэй бөгөөд тэр нь дэлгэрэх үедээ доош тонгойж байгаад сүүлдээ дээшээ эгц босно. Монгол орны хангай Хэнтий, Хөвсгөл, Монгол Алтайн уулархаг хэсгээр хайрга чулуу бүхий налуу, ойн зах зэрэг газраар элбэг ургаж хавар эрт 5-р сарын дунд үеэр цэцэглэн ургана.

Шувуун хөл



Шувуун хөл ойт хээр хээрийн хялгана, хазаар өвс, элдэв ургамалтай холилдсон хуурай газраар элбэг ургадаг. Үндэслэг ишээс хэд хэдээр гарсан төдий л том бус сонгинолог иштэй олон наст ургамал. Нарийн урт иштэй, ховил бүхий нарийн бортгон навчтай харилцан адилгүй хөлтэй баг цэцгүүдээс бүрдсэн шүхэр баг цэцэгтэй. Шувуун хөл бол малын тэжээлийн сайн чанартай бөгөөд хонь сайн иддэг, харин адуу тэмээ, үхэр базаахгүй иднэ. Намар бог мал иднэ. Өвөл хагдран ойчих тул үндсэн дээрээ үлдэхгүй.

Таана



Сонгинолог булцуу 2-4 см өндөр, 0.5 см голчтой бараг арьсархуу, хүрэн өнгийн хайрсаар хучигдсан, нягт дэгнүүл үүсгэдэг. Иш 10-25 см өндөр, нарийхан. Навчис 1-1.5 мм өргөн, хагас бортгон хэлбэртэй, ховилтой, захаараа намхан, өргөсөрхүү үстэй, ишнээсээ ялимгүй богино. Шүхэр өтгөн, тал бөмбөлөгөрхүү 2-3 см голчтой. Цэцгийн шилбэ шадар эрхтэнтэйгээ тэнцүү юмуу 1.5 дахин урт. Шадар эрхтний навчинцар 5-6 мм урт, гонзгойвтор, мохоо, бараандуу-ягаан. Дотор хүрээний дохиурын шилбэ $3/2-4/3$ хүртэл өргөссөний зэрэгцээ хоёр шүдлэгтэй.

Таван салаа



Хүний дотор эрхтэнд нэн сайн эмийн ургамал манай улсад ихээр ургадаг. Тэр тусмаа таван цул эрхтний үйл ажиллагаанд сайнаар нөлөөлдөг нь их. Сөд өвс, таван салаа гээд нэлээд эмийн ургамал байдаг. Таван салаа нь голын эрэг, эрэг дагасан нуга, мөлгөр хайрга, бургасан шугуй, улиасан төгөл, булаг шандын дагуух зүлэг зэрэг газар маш элбэг ургадаг эмийн ургамал. Уг ургамлын навчны ханд шарх эдгэрүүлэх агаад шинэ түүсэн навчны шүүс нь нүдний эвэрлэгийн шархыг түргэн эдгээх сайн талтай. Азийн олон орны эмнэлэгт навчаар

бэлтгэсэн хандыг уушигны багтраа зэрэг өвчний үед цэр ховхлох зорилгоор хэрэглэдэг. Мөн ходоод болон нарийн гэдэсний үрэвслийн үед онц тус үзүүлдэг ургамал юм. Хоолны халбага нунтаг навчийг 200мл буцламтгай усанд хийж, 15 минут болсны дараа шүүж аваад хоолны халбагаар өдөрт гурван удаа ууж хэрэглэнэ.

Дэрс



Иш 2м хүртэл өндөр нягт дэгнүүр үүсгэдэг олон наст өвслөг ургамал, бөгөөд ширүүвтэр, суурь хэсэгтээ цайвар хүрэн юмуу сүрлэн шар өнгийн навчны үлдэгдэл хэсгээр өвч хучигдсан.

Навч саарал, ширүүвтэр, гол судал дагуугаа хуулирдаг ба голчоороо 1-1.5мм. Үндэс орчмын навч урт бөгөөд олон. Хэлхэн 5-15 мм урт, үзүүрээдээ нарийсдаг. Залаа баг цэцэг 10-30см урт ба 5-15 см өргөн, хөх ягаан өнгөтэй, хоёр цэцэгт түрүүхэй 4-5 мм урт.

Цахилдаг



Нягт дэгнүүл үүсгэдэг ургамал. Иш 10-20 см өндөр. Үндэс орчмын навчис 15-50 см урт, 3-5 мм өргөн, цайвар ногоон, суурь хэсэг нь нарийхан ширхэгээр салбархайдсан хар хүрэн өнгийн угларгаар хучигдсан. Ороолт навчинцар хальслаг, нилээд өргөн, үрлэлтийнхээ үед цаасархуу болох ба ихэвчлэн хонхорцогны суурь хэсэгт хүрдэггүй. Нил-цэнхэр, хааяа цагаан 1-2 цэцэгтэй. Шадар эрхтний хоолой маш богинохон. Шадар эрхтний гадна эгнээний навчинцар 5-6 см урт, 1-1.5 см өргөн, түүний илтэс

тогоруу-юлдэн, хурц. Хонхорцог 3-6 см урт, ихэнх нь нарийн гонцгой юмуу ээрүүлэрхүү, 3-7мм урт шонтонтой.

Мангир



Иш 20-60 см өндөр, дээхнээ хавчгар, хоёр талынхаа ирмэгээр эмжээр буюу нимгэн хавчгар далавчтай. Навчис 4-8мм өргөн, хавтгай, шугамархуу, мохоо, хөх саарал, туушдаа шураг адил мунгиастай. Цэцэг ягаандуу, тал бөмбөлөгөрхүү өтгөн шүхэр үүсгэдэг, цэцгийн шилбэ нь шадар эрхтнээсээ 2-3 дахин урт. Дохиур шадар эрхтнээсээ 1.5

дахин урт, сууриадаа өргөн, ирмэгээрээ шүдгүй. Үр боловсрох орны багана шадар эрхтнээсээ урт.

Багваахай



Багваахай бол олон наст ургамал юм. Удвалынхан овогт багтдаг. Өвслөг урт, хоёр талдаа жад хэлбэрийн урт навчтай. Иймээс олон хэлэнд Франц хэлэнд dent-de-lion буюу “Арслангийн шүд” гэсэн утгаас гаралтай нэрээр нэрлэдэг. Багваахайн олонд танигдсан шар цэцэг нь 3-5 см диаметртэй ба тус тусдаа салж ургасан дэлбээ нь 4-20 см урттай байдаг. Дэлбээ нь өдөр нээгдэж. Шөнө хумигдаж хураагддаг.

ДОЛГИОНТ ГИШҮҮНЭ



Захаараа үрчгэр атираа бүхий 30 см урт том далбагар цөөн навчтай, 30-150 см өндөр хийгээд 4 см бүдүүн, жижиг бэрсүү үе бүхий гадаргуутай хөндий шулуун иштэй, 50-80 см урт бөгөөд 20 см бүдүүн, 7 кг орчим жинтэй хар хүрэн хайрст бүдүүн бахим салаархаг үндэстэй олон наст ургамал. Ишний дээд хэсгийн навчис нь жижигхэн, ишнээс бариулгүйгээр гардаг бол доод хэсгийн навчис нь бэрсүүтсэн урт бариултай. Улбар ногоондуу, заримдаа цайвар шаргал жижиг цэцэгс нь

ишний оройд урт залаа баг болон багсайдаг. Цэцэг нь гүвэгдсэний дараа дундуураа судалтай, гялгар хүрэн өнгийн далавчтай хүрэн өнгийн гурвалжин үр гардаг.

Амьтан

Махчин амьтан: Үнэг, чоно, шилүүс, хярс, мануул, дорго, өмхий хүрэн

Чоно



Сүргийн манлай, сүр хүчтэй энэ амьтан 14 нас хүрч амьдардаг. 2-9 нас нь үржлийн чадвартай үе нь юм. Азарган чоно нь өөр гичийд хавьтдаггүй, бусад азаргыг ч сүрэгт ойртуулдаггүй, хатуу хуультай. Чухал үед гичийдээ тусалж ан ав хийнэ.

Дорго



Дорго зүсээ хамелеон адил хормын төдийд өөрчилж чадахгүй ч жилийн дөрвөн улиралд тохиуруулан өнгөө сольж байдаг. Дорго нуруу сээрэн дээгүүрээ хар бор, хажуу хавирга орчмоороо цайвар, нүд чихийг бүрхсэн хар, дух хацрыг дагаж нарийн цайвар судалтай байдаг.

Улаан үнэг



Мах идэштэн багийн хөхтөн амьтан.

Өөр ямар ч чонынхон овгийн зэрлэг амьтангүй болсон Британийн арлууд дээр улаан үнэгийг зүгээр л “the fox” буюу үнэг гэдэг. Улаан үнэг нь хуурай газрын махан идэштний дунд хамгийн өргөн тархалттай зүй бөгөөд Канад, Алеска, АНУ, Европ, Хойд Африк, Ази түүний дотор Японд хүртэл тархсан. XIX зуунд улаан үнэгийг Австралид анх нутагшуулжээ. Их төлөв улаан хүрэн өнгийн үстэй боловч саарал зүсмийн үнэг байх нь бий. Үнэгний зулзагыг гавар гэдэг.

Хярс



Биеийн галбир төрхөөрөө үнэгтэй төстэй боловч илэрхий жижиг биетэй. Биеийн өнгө хул шаргалдуу саарал, сор үсний үзүүр цагаан тул мөнгөлөг туяатай харагдана. Сүүл богино үзүүр нь хар. Өвлийн үс тод улаан шаргал, зуны үс улбар цайвар. Амьдралын онцлог голдуу харуй бүрийгээр явдаг. Биеийн урт 25-36 см, чихний урт 6-9 см, биеийн жин 2-3 хүрнэ.

Мануул



Мануул нь Муурын овгийн махчин амьтан билээ. Уг зэрлэг муур нь ганцаар амьдрах бөгөөд бяцхан араатан бөгөөд биеийн урт нь гэрийн муурынхтай адил 50-60 см урт байдаг.

Муурын төрлийн амьтад дотроо хамгийн их үслэгтэйд тооцогдох бөгөөд саарал болон цайвар хүрэн зүстэй байдаг. Их бие нь 6-7 хөндлөн судал бүхий 21-31 см сүүлтэй, сүүлний үзүүр нь хар өнгөтэй.

Өмхий хүрэн



Өмхий хүрэн нь хүчтэй өмхий үнэртэй шингэн ялгаруулдаг Merhitidae овгийн хөхтөн амьтан юм. Нийт 4 төрөл 10 зүйл бий. Зүйлээс шалтгаалан хэмжээ нь өөр байх ба 40-94 см урт, 0.5-8.2 кг жинтэй байна. Урт бие, өтгөн саглагар сүүл, булчинлаг богино хөлтэй, урд савар нь газар малтахад зохицсон уртдуу байдаг. Хамгийн түгээмэл зүс нь хар цагаан алаг бөгөөд зарим нь бор, саарал, мөн цайвар

шардуу өнгөтэй байна. Бүх өмхий хүрэн төрөх үеэсээ нуруу болон сүүлэндээ судалтай. Тэд нэг бол бүдүүн цагаан судал, эсвэл нарийвтар 2 судалтай, зарим нь цагаан толбо, тасархай судлуудтай байна.

Мэргэчин амьтан: Тарвага, Туулай, алаг даага, зурам

Тарвага



Тарвага нь Хэрэмнийнхэн овгийн мэргэгч юм. Тарваганы төрөлд нийт 14 зүйлийн тарвага багтана. Эдгээрээс Монгол улсад Алтайн тарвага, хээрийн тарвага гэсэн хоёр зүйлийн тарвага байдаг. Цаг агаарын хүнд хомс байдлыг ичиж өнгөрөөнө. Ичээндээ голдуу бүлээрээ байдаг. Тарвага нь Монгол орны ойт хээр, уулын хээр, тал хээрт түгээмэл тархсан, мах арьсны үнэт үслэг ан юм.

Туулай



Туулай нь туйлын болон уулархаг бүсэд амьдрахад зохицсон амьтан юм. Урьд Уулын туулайн дэд зүйл гэгдэж байсан ч, тустаа зүйл болох нь тогтоогдсон. Тэд зузаан арьс үстэй бөгөөд газар цасанд нүх ухан орж унтан дулаацдаг. Голдуу ганцаар амьдрах ч заримдаа хэдэн арваараа байна. Тэдний гол дайсан нь туйлын чоно ажээ.

Оготно



Оготно нь хулганатай төстэй жижиг мэргэгч ба арай богино үсэрхэг сүүлтэй, бөөрөнхийдүү толгой, жижиг нүд, чихтэй юм. Нийт 155 зүйлийн оготно бий. Оготно нь Европ, Ази, Хойд Африк, Хойд Америк болон тундрын бүсэд амьдарна. Тэд 3-6 сар амьдрах ба ховр тохиолдолд 1 жил амьдардаг. Хамгийн урт тохиолдол 18 сар байв. Оготно нь ургамлын үр, болцуу, үндэс, холтос, шилмүүс болон өвс, хорхой шавьжаар хооллодог.

Зурам



Мэргэгчтэн баг, хэрмийн-хэн овгийн, шаравтар өнгөтэй, сагсгар сүүлтэй, жижиг мэргэгч амьтан, зүйл олон, нүх малтаж орно, өвс, ургамлын үр, навчаар идэшлэнэ, өвөл ичнэ.

Туурайтан амьтан: Цагаан зээр

Цагаан зээр



Монгол орны өмнө, дорнын уудам тал, ухаа толгодоор идээшиж бэлчдэг. Зээр нь голцуу 20-30-аараа сүрэглэнэ зарим үед 5000 хүртэл толгойтойгоор сүрэглэнэ. Цагаан зээрийн эрэгчинг ооно, эмэгчинг шаргачин, төлийг янзага, эрэгчин шүдлэнг цэнхэр ооно, охин шүдлэнг зусаг шаргачин гэнэ. Голдуу хул шар зүстэй, богино сүүлтэй, тангийнхаа захаар шар хүрээтэй, шаргачин нь эвэргүй, ооно нь арагшаа тахийж үзүүр нь дотогш эргэн ойртсон шорон хоёр эвэртэйгээрээ хар сүүлт зэргээс ялгаатай. Зургаадугаар сард янзаглана. Цагаан зээр хялгана, шаваг, хазаар өвс, үет ургамлаар хооллоно. Цагт дунджаар 70 км хүртэл хурдална.

Жигүүртэн

Нутагшмал шувууд: Бүргэд, бор шувуу, элээ, хэрээ, ятуу, тагтаа, шаазгай, сар, ууль, харцага, шонхор

Бүргэд



Бүргэд нь том биетэй махчин шувуу ба Харцагынхан овогт хамаарна. 60 гаруй зүйл байхаас ихэнх нь Еврази, Африкаар нутагладаг байна. Бүргэд нь бусад махчин шувуудаас хүчирхэг том бие, толгой, бахим хошуугаараа ялгарна.. Бүргэд нь 40см урт, 500гр жинтэй жижгээс 100см урт, 6,7кг хүртэлх жинтэй том төрөл хүртэл бий. Бүргэд нь дунджаар 25-30 наслах бөгөөд нь арай илүү урт амьдардаг. Эм бүргэд ихэвчлэн 4-р сарын эхээр 2 өндөг гаргана. Эхний өндөг гарсны дараа 4-5 хоногийн дараа дараагийн өндөг гарна. Ангаахай бараг ой хүртлээ эцэг эхээрээ тэжээлгэж, өд сөд нь ургаж гүйцэхээр нисэж сурна. Ингэхийн тулд эцэг эх нь ангаахайгаа үүрнээсээ түлхэж унагаадаг байна. Ангаахай өөрийн эрхгүй далавчаа дэвж нисэж сурдаг байна. Анд сургахын тулд тарвага туулай гэх мэтийг шархдуулан барьж авчраад хөөлгөж бариулах дасгал хийлгэдэг байна.

Тас



Тас (*Aegypius monachus*) мөн Нөмрөг тас, Нохой тас гэгддэг Харцагынхан овгийн өдрийн махчин шувуу. Монгол оронд Нөмрөг тас, Нохой тас хэмээх хоёр зүйл бий. Махчин шувуудаас биеэр хамгийн том номхон дөлгөөн шувуу. Тас хэзээ ч амьд амьтанд халддаггүй бөгөөд үхсэн амьтны сэг зэмээр хооллоно.

Хараа нь маш хурц учраас нисэж байх өндрөөсөө буюу заримдаа 10 мянган метрийн өндрөөс идэш тэжээлээ олж харж чаддаг. Биеийн жин нь 11-14 килограмм, алдасан далавчны урт нь 3 метр хүрнэ, хумс нь бат бахим боловч мохоо байдаг, толгойноос хүзүүний угийг хүртэл өд сөдгүй зулбан байдаг. Эм тас ихэвчлэн ганцаар амьдрах бөгөөд цавчим элгэн хад, хясаа бараадан үүрээ засч аваад 1-2 өндөг гарган 55 орчим хоног дарж ангаахай болгоно.

Ятуу



Монголд ховор шувуунд тооцогдох дагуурын ятуу байдаг бөгөөд газраар үүрээ засч, 8-16 өндөг гаргана. уулын хээр, хад чулуут толгод, нуга ойн цоорхой, бут сөөгт элсэн товцог, тариан талбайгаар амьдардаг. Заримдаа 20 гаруй өндөг гаргана. 29-30 см урттай, 0.2-0.4 килограмм жинтэй. Ятуу нь цагаан ятуу, цэвдгийн цагаан ятуу, дагуурын ятуу гэх мэт хэд хэдэн янз бий. Өчүүхэн дуу чимээг ч андахгүй сонсдог маш сэжигч, соргог шувуу учраас үзэж харсан хүмүүс цөөхөн байдаг

Болжмор



Болжмор нь бор шувуу хэлбэртэн жижиг шувуу юм. Энэхүү шувуу нь Европ, Ази болон Африкийн хойд хэсгийн уулархаг газраар амьдрана. Зүүн зүгийн болжморууд нь зүүдэллэх ба өмнийг зорин өвөлждөг.

Хэрээ



Хэрээ нь алагтуу, ятга шаазгай, алаг шаазгай гэх мэт шувууд багтах бор шувууны багийн шувуу юм. Антрактид ба Өмнөд Америкаас бусад бүх тив, эх газарт өргөн тархаж суурьшжээ. Хон хэрээ, саарал хэрээ, турлиах гэх мэт 40 гаруй зүйл байна.

Тагтаа



Тагтаа нь Columbidae овгийн шувуу юм. Өргөн тархсан ба хамгийн их суурьшсан нь Индонез болон Австралийн бүс нутаг болно. Тагтааны 300 орчим зүйл бий.

Тагтааны далавчны урт 20-27 см, жин нь 200-650 гр байдаг ба Евроази, Африк, Австралид өргөн тархсан байдаг.

Нүүдлийн шувууд: ангир, галуу, хун, нугас, тогоруу, цахлай, өвөөлж, хараацай

Тогоруу



Тогоруу нь Тогоруу хэлбэртэн багын тогорууныхан овгийн шувуу ба Евразийн тогоруу гэдгээр сайн танигдсан болно. Их бие нь саарал, нүүрнээс хүзүүрүү орсон цагаан судалтай. Сүүлний үзүүр хэсэгт хар өдтэй байна. Том сүрлэг шувуу бөгөөд дунд зэргийн хэмжээтэй тогорууны урт 100-130 см, далавчаа дэлгэхэд 180-240 см ба 4.5-6 кг жинтэй. Хол газар туулан нүүдэллэдэг бөгөөд Африкийн Марокко Этиоп болон Өмнөд Европ, Өмнөд Азийн Пакистан зэрэг улсын нутгаар өвөлждөг байна.

Хун



Хун шувуу нь 12-24 ширхэг буюу бусад шувуудаас 2 дахин урт далавчин өдтэй шувуу юм. Тэр ихэвчлэн гол нууртай газар амьдарна. Усанд сэлэхдээ сайн. Нисэхдээ уддаг ч гэсэн хөөрсөн тохиолдолд их хурдан ниснэ. Явахаас усанд байхыг илүүд үздэг. Голдуу ургамал, усан доорх ургамал өт, жижиг загас, шавжаар хооллоно. Хун хосоороо амьдарч ангаахайгаа мөн хамтдаа өсгөнө.

Идлэг шонхор



Идлэг шонхор маш том биетэй шонхор юм. Энэ зүйлийн шонхор зүүн Европоос авхуулаад зүүн зүгт Манжуур хүртэл тархсан. Гол төлөв нүүдлийн шувуу. Харин өмнө зүгт нутагладаг зарим популяц нь нүүдэллэдэггүй. Нүүдлийн идлэг шонхор нь Этиоп, Арабын хойг, хойд Энэтхэг, баруун Хятадад өвөлждөг. Дэлхий дээр 60 орчим зүйл шонхор байдгаас Монгол оронд 10 зүйл Шонхор тархжээ. Манай оронд тархсан. Шонхруудаас хамгийн том биетэй нь Идлэг Шонхор юм. 2010 онд явуулсан судалгаагаар Монгол оронд 6830 орчим идлэг шонхор байгаа гэсэн дүн мэдээ гарчээ. Энэ нь дэлхий дээрх нийт идэг шонхрын 45 орчим хувь нь манай манай улсад байна гэсэн үг юм. Идлэг Шонхрын нэг хос 4-5 өндөг гаргаж,

түүнээс 40-50 хувь нь бойждог байна.



Зуун хурга

6.Тусгай хамгаалалтанд орсон дурсгалт газар



Их Өлзийт уул
Аймгийн түүх соёлы өвд бүртгэгдэж тосгоны
тусгай хамгаалалтанд авсан.

Найрамдал хөшөө



Найрамдал хөшөө нь 1987 онд Өлзийт сум ЧСАА-н 10 жилийн ойгоор зориулан бүтээгдсэн. Аймгийн түүх соёлын өвд бүртгэгдэж тосгоны тусгай хамгаалалтанд авсан.

7. Байгалын баялаг, ашигт малтмалын орд газрын талаар

Сумын физик газар зүй , ашигт малтмал

Тосгоны нутаг бүхэлдээ Хэнтийн нурууны захын намхан уул толгодын дунд оршдог. Ашигт малтмал, уурхайн орд, боломж- хүрэн нүүрс, нөөцийг тогтоогоогүй. Давс 50 тн, 1100-1200м өндөр Чандганы тал, Чандганы талд нүүрсний баялаг орд бий.



Бөөний нүүрсний далд уурхай

Шорвог нуур



Шорвог нуур – Давс болон Лаг шүүг малчид өргөнөөр энэ нуураас авч хэрэглэдэг. Хэрлэн сумын тусгай хамгаалалтанд авсан газруудын нэг юм. Улаан нуур, Хөтөл нуур зэрэг олон нуурууд байдаг.

Чулуут булаг



Эмчилгээний журмаар ходоод, дотор эрхтний зарим өвчин, чихрийн шижин өвчний үед иргэд байнга хэрэглэдэг. Өвдөгийн булаг, Өвөр булаг, Тагийн булаг, Цоргийн булаг, Задгай булаг, Жаргалантын булаг зэрэг булгууд байдаг.



Жаргалантын булаг



Шандын булаг



Задгай булаг



Сүүжийн булаг



Ар хөвийн булаг



Их булаг



Байшингийн булаг



Өвөр булаг

Зүлэгт булаг



Хөтөл нуур





Өвдгийн булаг




Их Өлзийт уул /алсаас/



Их Өлзийт уул /дэргэдээс/



Хойд Зотлог уул



***Урд Зотлог уул
Тээг***



Адуун чулууны энгэр



Мөрөнгийн гол



Бүрд

8.Өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа ААН

- “Атар Чандгана Сүү” ХХК
- “Атар Чандгана” ХХК
- “Сайхан тал Номгон” ХХК
- “Уудам тал Өлзийт” ХХК
- “Өлзийт –ЭНСАДА” ХХК
- “Хөдөөгийн Зотлог” ХХК
- “Өндөрцагаан уул” хоршоо

УУДАМТАЛ ӨЛЗИЙТ ХХК



Анх 2006 онд П.Лутаа захиралтай байгуулагдсан. Хүнс барааны худалдаа, үйлчилгээ, талх нарийн боов, блок үйлдвэрлэл, хадлан бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж жил бүр 7-8 хүнийг түр ажлын байраар хангадаг. 2011 онд Өлзийт тосгоны шилдэг “Татвар төлөгч”, аймгийн “ТОП-100” аж ахуй нэгжийн нэгээр шалгарч байсан.

САЙХАН ТАЛ-НОМГОН ХХК



Өлзийт тосгоны “Сайхан тал-Номгон” ХХК нь 2003 оноос эхлэн байгуулагдаж 8 нэрийн хүнсний барааны дэлгүүр, талх гурилан бүтээгдэхүүн үйлдэрвэрлэлийн цех, мөн малчдын ноос, ноолуур түүхий эдийг хүлээн авч зах зээлд борлуулах үйл ажиллагаа явуулдаг. Мөн тосгондоо “Эко ногоон орчин” бий болгож хүүхэд багачуудыг тоглож наадах дуртай, таатай орчин бий болгож байгаа нь олны талархлыг хүлээж байна.

АТАР ЧАНДГАНА ХХК



Атар Чандгана ХХК нь эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, гадаад дотоод худалдаа, аялал жуулчлал зэрэг үйл ажиллагаа явуулах чиглэлээр байгуулагдсан. Нийт 20-иод мал аж ахуйн суурьтай. 7000 толгой малтай. Сүүлийн 10-аад жилд малчдыг дэмжих бодлогоор гэрээний үндсэн дээр 9 мянга гаруй толгой мал өгч малжуулсан.

АТАРЧАНДГАНА СҮҮ ХХК

Дарга Мянганцангийн Батчулуун



1967 оны 2 сарын 28-нд Улаанбаатар хотын Налайх дүүрэгт төрсөн. 1975 онд Өмнөговь аймгийн Цогтцэций сургуульд орж 1985 онд төгссөн. 1985 онд Санхүү Эдийн Засгийн техникумд орж 1987 онд нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. 1996 онд Санхүү эдийн засгийн дээд сургууль төгссөн. Эхнэр 4 хүүхдийн хамт амьдардаг. Одоо “Атар Чандган Сүү” ХХК-д захирлаар ажиллаж байна.

Гавъяа шагнал:

1985 онд Бүх ард түмний урлагийн их наадамд алтан медаль, 1988 онд Ажилчин залуу алтан медаль, 2007 онд Витавит группын үйлдвэрт аварга, 2008 онд Витавит группын шилдэг ажилтан, 2013 онд Сангийн яамны хүндэт жуух бичгээр шагнуулж байсан

Атарчандган сүү ХХК нь 2010 оноос эхлэн Хэнтий аймгийн Хэрлэн сумын 7-р баг Өлзийт тосгонд саалийн эрчимжсэн фермийн аж ахуй, газар тариалан хосолсон орчин үеийн эрчимжсэн фермийн аж ахуй байгуулагдсан юм. 2016 оны байдлаар 340 гаруй толгой үхэртэй, 2000 га тариалангийн талбайтай, 12 ажилчинтай, жилд 1 сая литр сүү сааж Витафит сүүний үйлдвэрт нийлүүлдэг. Цаашлаад 1000 үнээний ферм байгуулахаар зорилт тавин ажиллаж байна. 2012 оноос Олон улсын НАССР стандартын шаардлагад нийцүүлэн Япон улсын Орион фермд үйлдвэрлэсэн 32 үнээг нэг дор зэрэг саах цахилгаан саалтуурыг ашигласнааср хүний хөдөлмөрийг хөнгөвчилж эхэлсэн юм. Ингэснээр орчин үеийн технологиор стандартын шаардлага хангасан +4 градуст хадгалагдсан сүүг 48 цагийн дотор сүү тээвэрлэх зориулалтын машинаар боловсруулах үйлдвэрт нийлүүлж байна. 100 га талбайд услалтын систем барьж даршны эрдэнэшиш 3 жил дараалан ургуулж жилд дунджаар 1000тоннн дарш бэлтгэж хэвшсэн. 1000тн үр тарианы агуулах сэргээн засварлан ашиглалтанд оруулсан. 900 га-д үр тариа болон тэжээлийн ургамал тариалж хураах технологийн бэлтгэл хийх иж бүрэн үр тарианы техник 1000тн байгалийн хадлан бэлтгэх техникийн болон ажиллах хүчний байр суурийг бий болгосон.

2011 оны Улсын тэргүүн хадланч хамт олон /ХХААХҮЯ/

Хэнтий аймгийн Тэргүүний ажил олгогч байгууллага /Хэрлэн сумын ИТХ/
Хэнтий намрын баяр 2013-2015 оны шилмэл малын үзэсгэлэнд тэргүүн байр
2016 оны Өлзийт тосгоны шилдэг байгууллага
2017 оны Хэнтий аймаг Өлзийт тосгоны шилдэг татвар төлөгчөөр тус тус шагнагдсан.






Ө.ТӨГССАЙХАН ЗАХИРАЛТАЙ “ӨЛЗИЙТ ЭНСАДА” ХХК



“Өлзийт Энсада” ХХК нь 2012 онд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр “Сандэй агро” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 2013 онд компанийн өмчлөл өөрчлөгдөн “Өлзийт энсада” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Компанийн гүйцэтгэх захирлаар мал эмнэлгийн ухааны магистр Ө.Төгссайхан ажилладаг.

ХӨДӨӨГИЙН ЗОТЛОГ ХХК



Өлзийт тосгоны мал эмнэлгийг 1999 онд дуудлага худалдаагаар малын их эмч Н.Баяраа худалдан авч тус компанийг үүсгэн байгуулсан. Мал эмнэлгийн эмчлэх сэргийлэх арга хэмжээг 26 дахь жилдээ хийж гүйцэтгэж байна.

Эдгээр он жилүүдэд мал эмнэлгийн эмчилгээний эмчлэн сэргийлэх арга хэмжээг хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгэхэд бүхий л талаар идэвхи зүтгэл гарган тусалж дэмжиж байдаг ЗААлба, малчид хамт ажиллагсаддаа баярлаж явдаг юм.

Тосгоны Атар Чандгана ХХК, Атар Чандгана Сүү ХХК, 87 малчин өрхийн 4700 толгой малд мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээг хийж гүйцэтгэж байна.

Хэнтий аймгийн аж ахуйн нэгжүүдээс 2002, 2004 онд 1-р байр, 2001 онд сумын аварга аж ахуй нэгж, ХХААЯамны “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, 2013 онд Хэнтий аймгийн 90 жилийн ойн медаль, Мал эмнэлэг үржлийн алба байгуулагдсны 90 жилийн ойн медалиар тус тус шагнагдаж байсан.

Б.БУЯНЖАРГАЛ ЗАХИРАЛТАЙ “ГЕО АРВИЖИХ” ХХК

Гео–Арвижих ХХК нь 2015 оноос эхлэн газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгон Чандганы талд улаан буудай болон тосны ургамалын тариалатыг нийт 3000 га эргэлтийн талбайд хийж байна. Компанийн захиарлаар Б.Буянжаргал удирдан ажилладаг.

штаб”
нутагт
ангийн



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 232 ДУГААР АНГИ

Тус анги нь 1979 онд “Отрын малын нэртэйгээр Хэнтий аймгийн Галшар сумын анх байгуулагдсан бөгөөд 1982 онд цэргийн зохион байгуулалтад орж, 1989 оноос Дэлгэрхаан сумын нутагт шилжин байрласан.

Улмаар 1997 оноос зэвсэгт хүчний нөөцийн малын тодорхой хэсгийг Өлзийт тосгонд байршуулан маллаж, хөдөлмөрийн сайчуудыг олноор төрүүлэн гаргасан. Тухайлбал, Хөдөлмөрийн хүндэт медалиар Өлзийт тосгоны иргэн Р.Ганхуяг, Алтан гадас одонгоор Х.Сатыболд, БХЯ-ны хүндэт жуух бичгээр Н.Нямдаваа нар шагнагдсан.



1997 оноос хойшхи 19 жилийн хугацаанд Өлзийт тосгоны нийт 58 малчныг ажлын байраар хангаж ирсэн бөгөөд одоогоор 12 малчныг төрийн албан хаагчийн орон тоон дээр ажлын байраар ханган, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэн ажиллаж байна. Жил бүр малын бэлчээрийн татвар төлдөг, орон нутгийн засаг захиргаатай хамтран ажилладаг, малчдыг ажлын байраар хангадаг гээд ЗХ-ний 232

дугаар анги, Өлзийт тосгонтой байнгын хамтын ажиллагаатай байдаг.

Тус ангийн эрхэм зорилго, зорилтын хүрээнд Төрийн торгон сүрэг, мал ахуйг тогтоосон хэмжээнд байлган, удам угшлыг сайжруулан тоо толгой, чанар байдлыг алдагдуулахгүй маллах чиглэлд хамтран ажилладаг .



ӨНДӨРЦАГААН ХОРШОО

Тус хоршоо нь анх 2012 онд Г.Ган-Өлзий даргатай, 10 өрхийн 30 гишүүнтэйгээр байгуулагдсан. 2013 оноос Д.Оюунбаатар хариуцан авч одоог болтол даргаар нь ажиллаж байна. Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх, хадлан тэжээл бэлтгэх, малын түүхий эд бэлтгэн нийлүүлэх үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулдаг. 2013 онд тосгоны “Шилдэг татвар төлөгч”-өөр шалгарсан.

9.Цаашид хөгжүүлэх боломжтой үйлдвэрлэл үйлчилгээ, сумын хэтийн хөгжлийн талаарх мэдээлэл

Өлзийт тосгонд цаашид эрчимжсэн мал аж ахуй, усалгаат газар тариаланг хөгжүүлэх Хөдөө аж ахуйн агропаркийг байгуулах. Гахай тахианы аж ахуй эрхлэх, төмс хүнсний ногоо тариалах, жимс жимсгэний аж ахуй эрхлэх бүрэн боломжтой.

Утас: 99989986, 94469191, 94469292